



Малчны гэрээр орж, малчин ард иргэдтэй ярилцан санал солилцож буй нийг-
-мийн даатгалын ажилтан

Жайка Нийгмийн даатгалын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх төсөл

Мэдээлэл №1



2016 оны 8 сар

ҮНДСЭН АГУУЛГА (ДАРААГИЙН ХЭСЭГ)

“Нийгмийн даатгалын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх төсөл” эхэллээ !

2016 оны 5-р сарын 31-ны өдөр Япон улсын мэргэжилтнүүд томилогдон, “Нийгмийн даатгалын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх” (Project on Strengthening the Capacity for Social Insurance Operation) төслийн үйл ажиллагаа эхэллээ.

Нийгмийн даатгалын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх төсөл гэдэг нь ?

Монгол улсад, НДЕГ-ын нийгмийн даатгалын хамруулалт, шимтгэл хураалт болон даатгал олгох үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Жайка, Хөдөлмөр-Нийгмийн Хамгааллын Яам, Нийгмийн Даатгалын Ерөнхий газартай хамтран хэрэгжүүлж буй техник хамтын ажиллагааны төсөл юм.

Төслийн үйл ажиллагаа

НДЕГ болон дүүрэг, аймгуудын нийгмийн даатгалын хэлтсийн мэргэжилтнүүдэд зориулсан сургалт семинар зохион байгуулах, Япон улсад сургалт зохион байгуулах, японоос богино хугацааны мэргэжилтэн урьж ажиллуулах /даатгалын бүртгэл хөтлөлт, сайн дураар даатгалд хамрагдалтын хувь хэмжээг нэмэгдүүлэх, актуар тооцоо, сургалт сурталчилгаа олон

нийтийн мэдээллийн салбарт/ нийгмийн даатгалын мэргэжилтнүүдэд зориулсан сургалтын хөтөлбөр, гарын авлага зэргийг боловсруулна.

Жайка төслийн баг хамт олон

Ямашита Мамору мэргэжилтэн (ахлах зөвлөх)

Таканаши Акихиро мэргэжилтэн
(Нийгмийн даатгалын өдөр тутмын ажиллагаа хариуцсан)

Кикучи Эрика мэргэжилтэн (төслийн зохицуулагч)

Ч. Алтантуяа төслийн ажилтан

Л. Загдсүрэн төслийн ажилтан

Г.Ганбаатар төслийн жолооч



Ямашита зөвлөхийн цуврал нийтлэл

Монгол улсын нийгмийн даатгалын нөхцөл байдал болон тус төслөөр дамжуулан ойлгож мэдэрсэн зүйлийн талаар байнга танилцуулж байх болно. Энэ удаад та бүхэнтэй “Тал хээрийн Монгол орны нийгмийн хамгаалал” хэмээх сэдвээр сэтгэгдэлээ хуваалцъя.



Төслийн загвар дүүрэг, аймгуудын нийгмийн даатгалын ажилтай танилцсан байдал

Тус төслийн загвар дүүрэг болох Улаанбаатах хотын Баянгол, Хан-уул дүүрэг, Архангай, Төв аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагаатай танилцлаа.

Тал хээрийн Монгол орны нийгмийн хамгааллын талаар (Анхны нийтлэл)

Монгол улсын ЭМНДЕГ-тай хамтран “Нийгмийн даатгалын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлж байна. Төслийн ач холбогдлын талаар дурьдахын өмнө 55 жилийн өмнө Япон орны талаар товч танилцуулъя .

55 жилийн өмнө Япон орны 1 хүнд оногдох үндэсний нийт орлого 17 мянга 6 зуун иен байлаа. Тухайн үед 1ам долларыг 360 иенээр тооцоход 500 ам долларт ч хүрэхгүй байв. Одоогоос 55 жилийн өмнө буюу1961 онд манай улсын ард иргэд эрүүл мэндийн болон тэтгэврийн даатгалыг хэрэгжүүлж эхэлсэн. Урд оны 12 сард “Орлогыг 2 дахин нэмэгдүүлэх төлөвлөгөө” хэмээх санаачлагыг дэвшүүлж, нийгмийн хамгааллын үндэс суурийг бэлдэхийн зэрэгцээ 2 дах шатны үйлдвэрлэлийг дэмжсэнээр манай улсын эдийн засаг

эрчимтэй хөгжих эхлэл тавигдсан билээ. Үүний үр дүнд дундаж орлоготой нийгмийн давхарга нэмэгдэж, улмаар 2 дах шатны үйлдвэрлэлийг дэмжих ажиллах хүчин болон өргөн хэрэглээний бараа худалдан авагч хэрэглэгч нар Япон орны эдийн засгийг дэмжих гол хүчин болсон. Ингэснээр 13 жилийн дараа буюу 1974 онд 1 хүнд оногдох үндэсний нийт орлого 4,000 ам доллар давсан байна.

Одоо Монгол улсын 1 хүнд оногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 3,830 ам доллар болж, Зүүн өмнөд Азийн орон болох Тайландын 5,620 ам долларт хүрэхгүй ч, Филиппинд 3,540 ам доллар, Индонезид 3,440 ам доллар болж ойролцоо түвшинд хүрчээ. Гэвч, хөгжиж буй орнуудын алинд нь ч баян ядуугийн ялгаа их байсаар байгаа нь асуудлын гоцлоо болсоор байгаа билээ. Өндөр наслалт, өвчлөлт, ажилгүйдэл, өрх толгойлсон эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд зэрэг нь нийгмийн хөгжлөөс хоцорч, ядуу өрхүүдийн тоог нэмэгдүүлж буй хэцүү дүр төрх өнөөгийн өндөр сайхан барилга, олон машин сүлжилдсэн Улаанбаатар хотод ч гэсэн байсаар байна. Энэ мэтчилэн ядуурлын асуудалд анхаарлаа



↑УБ хотын “гэр хороолол” (ихэвчлэн амьжиргааны түвшин доогуур иргэд амьдардаг)-д амьдардаг өрх толгойлсон гэр бүл

хандуулж, тусламжын гараа сунгахын зэрэгцээ нийгмийн дундаж давхаргыг нэмэгдүүлснээр цаашид улс орны хөгжилд хувь нэмэр оруулах нь манай төслийн эцсийн зорилго билээ.

Төслийн Ахлах зөвлөх Ямашита Мамору

↑2015 оны байдлаар Япон улсын 1 хүнд оногдох үндэсний нийт орлого 36,680 ам доллар

Төслийн загвар аймаг, дүүргүүдийн нийгмийн даатгалын үйл ажиллагаатай танилцсан байдал

/2016 оны 6-р сарын 30-аас 7-р сарын 1-ны өдрүүдэд нийт 4~7хоног/

УБ хотын 2 дүүргийн (Баянгол, Хан-Уул) Нийгмийн даатгалын хэлтсийн өдөр тутмын үйл ажиллагаа болон УБ хот руу шилжих шилжилт хөдөлгөөн ихсэж, хүн ам эрс нэмэгдэж байгаатай холбоотой даатгалын өдөр тутмын ажлын ачаалал нэмэгдэж буй талаар,

түүнчлэн хөдөө орон нутаг болох Төв, Архангай аймгуудын нийгмийн даатгалын хэлтсийн ажилтай танилцан, сумын нийгмийн даатгалын байцаагчтай хамтран ажиллах ажлын уялдаа холбоо болон малчдыг нийгмийн даатгалд хамруулах ажилд учирч буй саад бэрхшээлийн талаар асууж тодрууллаа.



↑ Үйлчлүүлэгч ихтэй Нийгмийн даатгалын хэлтэс

←Нийгмийн даатгалын байцаагчийн яриаг сонсож буй иргэд



(Ажилтай танилцсан сар өдөр)

6 –р сарын 30-ны өдөр : УБ хотын Баянгол, Хан-Уул дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс

7-р сарын 1 -ны өдөр : Төв аймгийн •Баянхангай, Аргалант сум

7-р сарын 4 ~ 7 -ны өдрүүдэд : Архангай аймаг•Төвшрүүлэх, Цэнхэр, Ихтамир, Өндөр-Улаан, Тариат сум

ТӨСЛИЙН ХАЯГ·ХОЛБОО БАРИХ УТАС

Хаяг : Монгол улс, Улаанбаатар хот
Чингэлтэй дүүрэг, Хуульчдын гудамж 13/1
15160, ЭМНДЕГ-ын 2 давхар 206

Утас (факс) : (+976)-11-325125